4. Хариуцсан тоног төхөөрөмжийн найдвартай бэлэн байдлыг хариуцан ажиллана.
5. Ажлын байраа дур мэдэн орхин явахыг хориглоно. Ажлын байрыг зайлшгүй орхиж явах шаардлага гарвал ээлжийн инженерт мэдэгдэн зөвшөөрөл авсан байна.
6. Хүний амь насанд аюултай нөхцөлд ээлжийн инженерийн зөвшөөрөлгүй ажлын байрыг орхиж болно.
7. Илэрсэн гэмтэл доголдлын талаар ээлжийн даргад мэдээлж засварлуулах арга хэмжээг авахуулна.
8. Ажил гүйцэтгэхдээ хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
9. Аваарь гал эсэргүүцэх дасгал, техникийн хичээлд цаг тухайд нь идэвхтэй оролцож өөрийн мэдлэгээ дээшлүүлнэ.
10. Өөрийн буруугаас осол, зөрчил, гэмтэл, доголдол гаргалгүй ажиллана.
11. Хариуцсан тоноглолын бэлэн байдлыг хангах ба засварт орох насосуудын тоноглолын таслалт, залгалтыг хийх ба ажлын байр бэлдэнэ.
12. Станцад аваарийн байдал үүссэн үед аваарийг богино хугацаанд арилгах талаар хууль, дүрмийг мөрдлөг болгон мэрийн ажиллана.
13. Өөрийн хариуцсан тоног төхөөрөмжүүдэд үзлэг шалгалтыг 2 цаг тутамд хийж хариуцсан удирдлагадаа мэдэгдэж байна.
14. Хариуцсан тоноглолын үйл ажиллагаанд хяналт тавьж найдвартай ажиллагааг ханган ажиллана.
15. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлж, биелэлтийн талаархи мэдээллийг эргэж мэдэгдэж байна. /Шуурхай ажиллагааны хяналт мэдээллийн систем мөрдөж ажиллах/
16. Ээлж хүлээлцэх, ээлжинд ажиллах болон бусад дүрэм, журам, зааврыг биелүүлж, хяналт тавьж ажиллана.
17. Ажлын байрны эмх цэгц, ариун цэврийг ямагт цэвэр байлгаж ажиллана.
18. Дулааны горим барих ажилтай холбогдсон усны норм, даралт, зарцуулалтын горим ажиллагаанд оролцож ажиллана.

19. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад өөртөө болон хамт ажиллагсадын аюулгүй ажиллагаа, эрүүл мэндэд онцгой анхаарч, осолгүй ажиллах үүрэг хүлээж ажиллана.
20. Шуурхай ажиллагааны журнал хөтлөнө.
21. Хөдөлгүүр, машин, механизмын хэмжигч багаж, төхөөрөмжийг шалгах, тэмдэглэл хөтлөх, илэрсэн зөрчил, доголдлыг шууд удирдлагадаа мэдэгдэнэ.

<p>БОЛОВСРУУЛСАН: Гүйцэтгэх Захирлын 2018 оны А/02 дугаар тушаалаар томилогдсон Мэргэжил, албан тушаалын тариф мэргэжлийн лавлах боловсруулах ажлын хэсэг</p> <p>Боловсруулж дууссан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр.</p>	<p>БАТЛАВ: Амгалан дулааны станц ХХК-ийн Гүйцэтгэх захирал</p> <p style="text-align: right;">Ш.Баянмөнх</p>  <p>Баталсан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр.</p>
<p>ХЯНАСАН: Зуухан цехийн Ашиглалтын инженер Зуухан цехийн Засварын инженер Захиргаа, удирдлагын хэлтсийн Хуулийн мэргэжилтэн ХАБЭА-ийн инженер</p> <p style="text-align: right;">Э.Ариунболд Б.Боргил Г.Саруул А.Энхжаргал</p>	

**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ХХК-НИЙ ЗУУХНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН
VI ЗЭРГИЙН ЗАСВАРЧНЫ АЖЛЫН БАЙРНЫ ТАРИФ МЭРГЭЖЛИЙН
ЛАВЛАХ -7126**

АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

Бүрэн дунд ба түүнээс дээш боловсролтой, ЭХТСҮЦогцолборт Зуухны тоног төхөөрөмжийн засварчны мэргэжилтэй, даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрмийн сургалтад хамрагдаж үнэмлэхжсэн байх, Эрчим хүчний салбарт 5-аас доошгүй жил ажилласан, тоноглолын гэмтэлийг илрүүлэх чадвар эзэмшсэн, гал унтраагуул ашиглах чадвартай, хараа, сонсгол, амьсгалын замын болон зүрх судасны архаг үрэвсэл, харшилгүй, эрүүл чийрэг, сэтгэцийн ямар нэгэн өөрчлөлтгүй байх.

АЖЛЫН ТОДОРХОЙЛОЛТ:

Бүх төрлийн тоосго, галд тэсвэртэй материал, тусгаарлах материалаар өрлөг тусгаарлалтын ажил хийх, өрлөг тусгаарлалтанд үзлэг, температурын хэмжилт хийж гэмтлийг засварлах, өрлөг шавардлага, тусгаарлалтын гологдлыг илрүүлж устгах, өндөр параметртэй дулааныг дамжуулах шугам хоолойн тусгаарлалтын ба өрлөг тусгаарлалтын хариуцлагатай ажлыг хийж гүйцэтгэх болон засварын бригадыг удирдах, бүх төрлийн өрлөг тусгаарлалтыг зургийн дагуу, бүх параметрийн зуухны өрлөгийн их засвар хийх, засварын ажлын эзлэхүүн тодорхойлох, нэг үет тусгаарлалтын температурыг тодорхойлох, туршилт хийх, шаардлагатай материалыг сонгох, зуухны агрегатын бэлэн болсон өрлөгийг шалган хүлээн авах ба галд тэсвэртэй нарийн зуурмаг бэлтгэх, зуухны агергатын эд ангийг угсрах, засварлах, задаргаа хийх, тоноглолын тусгай эд ангийн түргэн элэгдлийн шалтгааныг тодорхойлох, гагнуурын формуляр хөтлөх ба хэмжилт үйлдэх, эд ангийн зангилгааг зурагтай тохируулан хянах, бүх төрлийн шугам хоолойн нягтруулгыг зургийн дагуу хийж гүйцэтгэх.

Бүх төрлийн хамгаалах клапан тохируулах, ямар ч системийн арматурын засвар ба деталийг бэлдэх ба коллекторын суурийг шинэчилж байрлуулах, хаалтны нягтруулах гадаргуугийн сэргээлт, редукторыг солих, бүх төрлийн насос, утаа сорогч, салхилуурын голд төвлөрүүлэлт хийх, өргөх зөөх хэрэгсэл, хийн, цахилгаан багаж хэрэгсэлийн тусламжаар ажил гүйцэтгэх, бригадын гүйцэтгэсэн ажлыг шалгах, хүлээн авах, складаас авч буй запас хэрэгсэл нь техникийн нөхцөл, шаардлагын хэмжээнд тохирох эсэхийг шалгах, засвараас гарсан тоноглол эд ангийг бэлтгэх болон зуухны агрегатын механизмыг шалгаж туршин ачаалал авахуулж ашиглалтанд хүлээлгэн өгөх, засаж буй машин, агрегат тоног төхөөрөмжийн хийцийн онцлог, тэдгээрийн /физик, механикийн үндсэн хуулиуд/ кинематикийн болон гидросхем, тоног төхөөрөмжийг засах, угсрах, ажиллагааны нарийвчлалыг шалгах болон тэдгээрийг засварын дараа механизмын ачааллын дээд хэмжээ, хугарах, зэвэрч элэгдэх ба осол гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах ажлыг гүйцэтгэх.

МЭДВЭЛ ЗОХИХ ЗҮЙЛ:

Бүх төрлийн өрлөг, тусгаарлалтын материалуудын шинж чанар, зориулалт, зуухны тусгай элементийн шавардлагын технологи ажиллагаа, жирийн ба хэлбэрт тоосгыг өрөх арга, засварлаж байгаа агрегатын өрлөг шавардлагын зангилгааны зохион байгуулалт, тусгай бодисын хольцтой шавар зуурах, шавж хатаахад бэлтгэх журам, металл бүрхүүлээр хучигдах шугам хоолойн тусгаарлалтанд тавих шаардлага, тусгаарлалтыг бөх бат ба дулаан дамжуулах чанараар нь шалгах арга, тоноглолын өрлөгийн нарийн зохион байгуулалт ба технологи ажиллагаа, өрлөгийн ажлын дэс дараалал, өрлөг шавардлагын засвар ба өрөлтийн техникийн нөхцөлд галд тэсвэртэй зуурмаг, гэмтэхийн эсрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээ, тусгаарлагдах гадаргууны 1м^2 , 1 погонметрт орох тусгаарлах материалын хэмжээ, засварын ажлын эзлэхүүн зэргийг тодорхойлох арга, зуух болон түүний туслах тоноглолын техникийн үндсэн нөхцөл, зуухны төрөл, параметр, утаа сорогч ба буцаах салхилуур, нүүрс тэжээгчүүд, агаар халаагч, усны экономайзер, хаалт, арматурууд, АҮК, засварын хоорондох найдвартай үргэлжлэх хугацаа зэрэг зуухны агрегатын хэвийн ажиллагааны техникийн үндсэн зарчим, гэмтэл үүсгэх шалтгаан, гол төлөв гардаг үндсэн согог гэмтлүүд, зуухны халах гадаргуу, тогоо, коллектор, экономайзер агаар халаагч, сорох, үлээх төхөөрөмж, зуухны халах гадаргуугийн бохирдох шалтгаан түүнтэй тэмцэх арга, засварлаж буй зуухны зарчимын схем, тэжээлийн шугам хоолой, дренаж, зуухан дахь агаар, халуун хийн хөдөлгөөнийн зам, шингэн, хатуу, хийн түлшийг бэлтгэх дамжуулах, утаа сорогчийн төрөл, элэгдлийн үндсэн шалтгаан, үлээх салхилуурууд тэдний үндсэн тодорхойлолт (циклон, уутат шүүлтүүр) үнсний бункерийн үндсэн төрөл, зуухны агрегатын засварт хэрэглэж байгаа материалууд (ус төрөгч багатай чанар сайтан ган, халах гадаргуу хоолой)-нд зориулагдсан сайн чанарын их ба бага хольцтой гангууд, ширэм, бронз, баббит, чанарын цувимал, нүүрстөрөгчийн хольцтой ган гагнахад зориулсан электрод, нүүрстөрөгч хольцтой хоолойн чанарыг тодорхойлох, редуктор солих, бүх төрлийн насос, утаа сорогч, салхилуурын голд төвлөрүүлэлт хийх аргууд.

Ажлын биеийн параметрээс хамаарч хаалт, арматурыг шалгах, зуух, экономайзер, I, II ба III зэргийн шугам хоолой, даралтан дор ажиллах сав, өргөгч кран тэднийг турших хугацаа бүх төрлийн өргөх хэрэгслийг ажилд хэрэглэх өргөх төхөөрөмж, ачаа өргөх машин, ачаа дэгээдэх хэрэгсэл, даавуун чалк, тросс, штроп, өргөх хэрэгслийг хадгалах ба турших дүрэм, зуухны тоог засварлах дараалал ба зохион байгуулалтын ажил, ААД, ТАД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, компанийн хэмжээнд мөрдөгдөх дүрэм, журам, Эрчим хүчний салбарт мөрдөгдөх дүрэм, журам, бусад хууль тогтоомжууд.

ХИЙГДЭХ АЖЛЫН ЖИШЭЭ:

1. Өрлөг, дахин өрлөг хийх хэмжээг тодорхойлох ханын өрөлтийн хэсэгчлэл, хөндий өрөлт, мөрөгцөг (свод) зэргийг зургийн дагуу хийх ба температурын заадсыг сэргээж хийнэ.

2. Өрлөгийн шинж байдлаас хамаарч зуурмаг, тоосго өрлөгт тохирох эсэхийг тодорхойлно.
3. Галын хотлоос утаа сорох хоолойн өрлөгийн шаваас хийнэ.
4. Өрлөгийн металл хийцтэй нийлэх, түүний зөв өрөгдөж байгааг шалгах, засна.
5. Заадсын зузаан, түүний босоо ба хэвтээ чигийн өрлөг зөв эсэхийг шалгана.
6. Шамот, бетоноор хийгдсэн хана ба мөрөгцөгийн зохион байгуулалт
7. Өрлөг шавардлагын хатаалтанд хяналт тавина.
8. Коллекторын тусгаарлагчийн өрлөг хийнэ.
9. Тохируулах клапан, бойлер, ус халаагчийн тусгаарлалт хийнэ.
10. Бүх төрлийн тусгаарлалтанд туршилт хийнэ.
11. Тусгаарлалт хийх гадаргуу түүнд орох тусгаарлах материалын хэмжээг тодорхойлон дахин тусгаарлалт хийнэ.
12. Өрлөгийн байдалд үзлэг хийж засварын ажлын эзлэхүүнийг тодорхойлно.
13. Өрлөг шавардлагын материалыг сонгон авна.
14. Галд тэсвэртэй материалыг ажлын байранд өгөхийг зохион байгуулна.
15. Секцийн өрлөг ба секцтэй зуухны хажуугийн яс төмрийн өрлөг хийнэ.
16. Ширмэн тоног суурилуулахтай холбогдсон өрлөг шавардлагын нарийн ажлыг хийнэ. Бүх системийн усны хаалт арматурт шингэн туршилт хийнэ.
17. Ямар ч системийн үлээх салхилуурын деталийн үзлэг шалгалт, засвар туршилт хийнэ.
18. Зуухны хаалтыг задлах, шалгах, нягтруулах, гадаргуу ба деталийг сэргээх, угсрах, засварлана.
19. Зуухны хамгаалах клапаныг сэргээх, тохируулга хийнэ.
20. Компрессорыг шалгах, засварлана.
21. Бүх төрлийн насосыг задлах, үзэж шалгаж засварлах, угсарна.
22. Насос, салхилуур, утаа сорогчийн голны тайван ба хөдөлгөөнтэй төвлөрүүлэлт хийнэ.
23. Шугам хоолойд шингэн туршилт хийнэ.
24. Нарийн багаж хэрэгсэлээр хэмжилт хийнэ. /микромметр, штангенцикуль, өнцөг хэмжигч, шүб, градус тодорхойлогч/
25. Сантехникийн угсралт, засвар үйлчилгээ хийнэ.
26. Асаагуур солино.
27. Хамгаалах клапаныг шалгана.
28. Зуухыг усаар шахаж турших, засварын дараа гэмтлийг илрүүлэх, засна.
29. Зууханд үзлэг хийнэ.
30. Экономайзерын змеевикүүдийг солино. (муруй хоолой)
31. Редукторыг задлах, цэвэрлэх, угсарна.
32. Буцлах ба ус халаах хоолойны вальцовкийн чанар шалгана.
33. Уутат шүүлтүүрийг засварын дараа туршина.
34. Галын хотлын экран хоолой солино.
35. Хувийн хамгаалах хэрэгсэл /хөдөлмөр хамгааллын хувцас, гутал, каск/-ийг тогтмол, аюулгүй ажиллагааны дүрэмд заасны дагуу хэрэглэнэ. ААД,

ТАД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, компанийн хөдөлмөрийн дотоод журам, Эрчим хүчний салбарт мөрдөгддөг бусад хууль тогтоомжийн заалтуудыг мөрдөж ажиллана.

36. Техник ашиглалтын дүрэм, аюулгүй ажиллагааны дүрэм, ажлын байрны тодорхойлолт, тоног төхөөрөмжийн ашиглалтын заавар, галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, анхны тусламж үзүүлэх заавруудаар тогтсон хугацаанд ээлжит шалгалтыг өгсөн байна.

<p>БОЛОВСРУУЛСАН: Гүйцэтгэх Захирлын 2018 оны А/02 дугаар тушаалаар томилогдсон Мэргэжил, албан тушаалын тариф мэргэжлийн лавлах боловсруулах ажлын хэсэг</p> <p>Боловсруулж дууссан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр.</p>	<p>БАТЛАВ: Амгалан дулааны станц ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх</p>  <p>Баталсан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр.</p>
<p>ХЯНАСАН: Зуухан цехийн Ашиглалтын инженер Э.Ариунболд Зуухан цехийн Засварын инженер Б.Боргил Захиргаа, удирдлагын хэлтсийн Хуулийн мэргэжилтэн Г.Саруул ХАБЭА-ийн инженер А.Энхжаргал</p>	

**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ХХК-НИЙ ЗУУХНЫ ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖИЙН V ЗЭРГИЙН ЗАСВАРЧНЫ АЖЛЫН БАЙРНЫ
ТАРИФ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ -7126**

АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

Бүрэн дунд ба түүнээс дээш боловсролтой, ЭХТСҮЦогцолборт Зуухны тоног төхөөрөмжийн засварчны мэргэжилтэй, даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрмийн сургалтад хамрагдаж үнэмлэхжсэн байх, Эрчим хүчний салбарт 4-өөс доошгүй жил ажилласан, тоноглолын гэмтэлийг илрүүлэх чадвар эзэмшсэн, гал унтраагуул ашиглах чадвартай, хараа, сонсгол, амьсгалын замын болон зүрх судасны архаг үрэвсэл, харшилгүй, эрүүл чийрэг, сэтгэцийн ямар нэгэн өөрчлөлтгүй байх. Краны операторчины мэргэжил эзэмшиж, үнэмлэхжсэн ажилтан нь өргөх, зөөх механизм дээр ажиллах эрх үүргийг хүлээнэ.

АЖЛЫН ТОДОРХОЙЛОЛТ:

Бүх төрлийн өрлөг тусгаарлалтыг зургийн дагуу, бүх параметрийн зуухны өрлөгийн их засвар хийх, өрлөг тусгаарлалтанд үзлэг хийж засварын ажлын эзлэхүүн, нэг үет тусгаарлалтын температурыг тодорхойлох, туршилт хийх, шаардлагатай материалыг сонгох, зуухны агрегатын бэлэн болсон өрлөгийг шалган хүлээн авах ба галд тэсвэртэй нарийн зуурмаг бэлтгэх, өрлөг тусгаарлалтын засварчдын бригадыг удирдах, зуухны бүх эд ангийг задлах, угсрах ажил (халах гадаргуу тогоо, коллектор, түлш асаагуур, үнс зайлуулах төхөөрөмж, ямар ч параметрийн хий, усны шугам хоолой) эд ангийг 1-2-р зэргийн нарийвчлалтайгаар слесарийн боловсруулалт, тохируулах хийх, шалгалтын хийн, усны хаалтуудын засвар, зуухны тусгай эд ангийг өөрчлөх, солих ямар ч параметрийн халах гадаргууг засах, шалгах, гэмтлийг илрүүлэх, гулсах ба өнхрөх холхивчийн элэгдлийн хэмжээг тодорхойлох, янз бүрийн шүдтэй тэгш ба хорхой араат редукторын их засвар хийх, зуухны агрегат, түүний эд ангиудыг шингэн туршилтанд бэлтгэх, ротор, төрөл бүрийн дугуйд хөдөлгөөнгүй төвлөрүүлэлт хийх, гар болон цахилгаан таль ажиллуулах, сантехникийн засвар үйлчилгээ хийх, гагнуур шалгах, бүх төрлийн шугам хоолойд зураг схемийн дагуу нягтруулга хийх, эргэх механизмыг турших шалгах, доргионы хэмжээ, түүний үүсэх шалтгааныг тодорхойлох, уутат шүүлтүүр ба түүний эд ангиуд, үнс тээвэрлэх систем, үнсний бункер, хөргөх систем, утаа ба агаарын хийн хөндий, түүний эд анги, нүүрс тэжээгч, утаа сорогч, салхилуурууд, өндөр даралтын салхилуурууд зэрэг зуухны эд ангийн төрөлжсөн засварт хэсэг, бригадыг удирдах зэрэг ажлыг хийж гүйцэтгэнэ. Бригадын гишүүдийн гүйцэтгэсэн ажлыг хүлээн авах, засварлагдсан тоног төхөөрөмжийг шалгах, түүнийг ашиглалтанд өгөх зэрэг ажлыг хийж гүйцэтгэнэ.

МЭДВЭЛ ЗОХИХ ЗҮЙЛ:

Өрлөгийн зохион байгуулалт ба технологи ажиллагаа, өрлөгийн ажлын дэс дараалал, өрлөг шавардлага ба өрөлтийн техникийн нөхцөлд галд тэсвэртэй зуурмагын чанар, гадаргууд шавах, хатаах, тусгаарлалтын бөх бат ба дулаан дамжуулах чанараар нь шалгах журам, тусгаарлалт элэгдэж муудах, гэмтэхийн эсрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээ, тусгаарлах гадаргууны 1м², 1 погонметрт орох тусгаарлах материалын хэмжээ, засварын ажлын эзлэхүүн зэргийг тодорхойлох арга, тоног төхөөрөмжийн засварт гаргах хугацаа, туслах тоноглол,


зуухны эд анги, ажлын нөхцөл, бүтэц, зориулалт (экономайзер, уутат фильтр, үлээх төхөөрөмж, асаагуур, ус, хийн шугам хоолой) зуухны ажиллагааны үед гарах гэмтэл, түүнтэй тэмцэх арга, утаа сорогч, салхилуур, насос, редуктор болон бусад тоног төхөөрөмжийн голын хөдөлгөөнтэй ба төвлөрүүлэлттэй, хэрэглэгдэх материалын шинж чанар, хоолойг төрөлжүүлж ангилах төрөл бүрийн зориулалт бүхий шугам хоолой, халах гадаргуугийн засвар, солиход зориулагдсан хоолойг ялгах, ган хоолой матах, нугалахад ба гагнуурт холбоход зөвшөөрөх хэлбэлзэл болон холбоосонд дулааны боловсруулалт хийх, вальцовкад хоолой бэлтгэх, вальцовк хийх, экономайзер ба агаар халаагч шугам хоолой шинээр бэлтгэх, зуухны тоног төхөөрөмжийн угсралт, зөвшөөрөгдөх зай, редуктор, зуухны бүх төрлийн арматур, гулсах өнхрөх холхивчийн угсралт, зуухны халах гадаргууг хэт халалтаас хамгаалах, арматурын нягтруулах гадаргуу, фланцын холбоос, ачаа өргөх машин, өргөх багаж хэрэгсэл, төхөөрөмж зууханд зөөх өргөх ажил зэргийн техникийн шаардлага, халах гадаргуу, утаа сорогч ба бусад эд ангийн холхивчийн элэгдлийг багасгах, зуух, түүний тусгай шугам, ажлын эзэлхүүнээс хамааруулж шингэнээр шахаж турших арга, зуухны агрегат, эд анги машин механизм, тоног төхөөрөмжийн элэгдлийн норм, ААД, ТАД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, компанийн хэмжээнд мөрдөгдөх дүрэм, журам, Эрчим хүчний салбарт мөрдөгдөх дүрэм, журам, бусад хууль тогтоомжууд.

ХИЙГДЭХ АЖЛЫН ЖИШЭЭ:

1. Бүх төрлийн тусгаарлалтанд туршилт хийнэ.
2. Тусгаарлалт хийх гадаргуу түүнд орох тусгаарлах материалын хэмжээг тодорхойлон дахин тусгаарлалт хийнэ.
3. Өрлөгийн байдалд үзлэг хийж засварын ажлын эзлэхүүнийг тодорхойлно.
4. Өрлөг шавардлагын материалыг сонгон авна.
5. Краны операторчины мэргэжил эзэмшиж, үнэмлэхжсэн ажилтан нь өргөх, зөөх механизм дээр ажиллана.
6. Секцийн өрлөг ба секцтэй зуухны хажуугийн өрлөг хийнэ.
7. Асаагуур солино.
8. Хамгаалах клапаныг шалгана.
9. Зуухыг усаар шахаж турших, засварын дараа гэмтлийг илрүүлэх, засна.
10. Зууханд үзлэг хийнэ.
11. Экономайзерын змеевикүүдийг солино. (муруй хоолой)
12. Редукторыг задлах, цэвэрлэх, угсарна.
13. Буцлах ба ус халаах хоолойны вальцовкийн чанар шалгана.
14. Уутат шүүлтүүрийг засварын дараа туршина.
15. Галын хотлын экран хоолой солино.
16. Нарийн багаж хэрэгсэлээр хэмжинэ. /микромметр, штангенцикуль г.м/
17. Сантехникийн угсралт засвар үйлчилгээ хийнэ.
18. Хувийн хамгаалах хэрэгсэл /хөдөлмөр хамгааллын хувцас: өмд цамц, бээлий, маск, нүдний шил, гутал, каск, шаардлагатай үед ажлын тусгай хувцас /-ыг тогтмол, аюулгүй ажиллагааны дүрэмд заасны дагуу хэрэглэнэ. ААД, ТАД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, компанийн хөдөлмөрийн

дотоод журам, Эрчим хүчний салбарт мөрдөгддөг бусад хууль тогтоомжийн заалтуудыг мөрдөж ажиллана.

19. Техник ашиглалтын дүрэм, аюулгүй ажиллагааны дүрэм, ажлын байрны тодорхойлолт, тоног төхөөрөмжийн ашиглалтын заавар, галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, анхны тусламж үзүүлэх заавруудаар тогтсон хугацаанд ээлжит шалгалтыг өгсөн байна.

<p>БОЛОВСРУУЛСАН: Гүйцэтгэх Захирлын 2018 оны А/02 дугаар тушаалаар томилогдсон Мэргэжил, албан тушаалын тариф мэргэжлийн лавлах боловсруулах ажлын хэсэг</p> <p>Боловсруулж дууссан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр.</p>	<p>БАТЛАВ: Амгалан дулааны станц ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх</p>  <p>Баталсан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр.</p>
<p>ХЯНАСАН: Зуухан цехийн Ашиглалтын инженер Э.Ариунболд Зуухан цехийн Засварын инженер Б.Боргил Захиргаа, удирдлагын хэлтсийн Хуулийн мэргэжилтэн Г.Саруул ХАБЭА-ийн инженер А.Энхжаргал</p>	

**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ХХК-НИЙ ЗУУХНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН
IV ЗЭРГИЙН ЗАСВАРЧНЫ АЖЛЫН БАЙРНЫ ТАРИФ МЭРГЭЖЛИЙН
ЛАВЛАХ -7126**

АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

Бүрэн дунд ба түүнээс дээш боловсролтой, ЭХТСҮЦогцолборт Зуухны тоног төхөөрөмжийн засварчин, сантехникийн засварчины мэргэжилтэй, даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрмийн сургалтад хамрагдаж үнэмлэхжсэн байх, Эрчим хүчний салбарт 3-аас доошгүй жил ажилласан, тоноглолын гэмтэлийг илрүүлэх чадвар эзэмшсэн, гал унтраагуул ашиглах чадвартай, хараа, сонсгол, амьсгалын замын болон зүрх судасны архаг үрэвсэл, харшилгүй, эрүүл чийрэг, сэтгэцийн ямар нэгэн өөрчлөлтгүй байх. Краны операторчины мэргэжил эзэмшиж, үнэмлэхжсэн ажилтан нь өргөх, зөөх механизм дээр ажиллах эрх үүргийг хүлээнэ.

АЖЛЫН ТОДОРХОЙЛОЛТ:

Өрлөг шавардлага, тусгаарлалтын гологдлыг илрүүлж устгах, өндөр ба хэт өндөр параметртэй дулааныг дамжуулах шугам хоолойн тусгаарлалтын ба өрлөг тусгаарлалтын хариуцлагатай ажлыг хийж гүйцэтгэх болон засварын бригадыг удирдах 2-3-р зэргийн нарийвчлалтайгаар чухал деталиудын слесарийн боловсруулалт хийх, янз бүрийн тэмдэглэх хэвийг бэлтгэх, цахилгаан ба хийн (дамжлагатай) багаж хэрэгслээр ажиллах, тохируулга хийх, зууханд төвөгтэй өргөх зөөх ажил гүйцэтгэх, гар болон цахилгаан таль ажиллуулах, сантехникийн засвар үйлчилгээ хийх, тоног төхөөрөмжийн эд ангийг задлах угсрах, тохируулах, тоног төхөөрөмжинд гарсан гэмтлийг илрүүлэх ба түүнийг устгах, зуухны төхөөрөмж, эргэх механизм халах гадаргууны засварын явцад шаардлагатай хэмжилтүүд хийх, зуухны агрегат, түүний эд ангиудыг шингэн туршилтанд бэлтгэх, ротор, төрөл бүрийн дугуйд хөдөлгөөнгүй төвлөрүүлэлт хийх, гагнуур шалгах, бүх төрлийн шугам хоолойд зураг схемийн дагуу нягтруулга хийх, уутат шүүлтүүр ба түүний эд ангиуд, үнс тээвэрлэх систем, үнсний бункер, хөргөх систем, утаа ба агаарын хийн хөндий, түүний эд анги, нүүрс тэжээгч, утаа сорогч, салхилуурууд зэрэг зуухны эд ангийн төрөлжсөн засварт хэсэг, бригадыг удирдах зэрэг ажлыг хийж гүйцэтгэнэ.

МЭДВЭЛ ЗОХИХ ЗҮЙЛ:

Бүх төрлийн өрлөг, тусгаарлалтын материалуудын шинж чанар, зориулалт, зуухны тусгай элементийн шавардлагын технологи ажиллагаа, жирийн ба хэлбэрт тоосгыг өрөх арга, засварлаж байгаа агрегатын өрлөг шавардлагын зангилгааны зохион байгуулалт, шугам хоолойн тусгаарлалтанд тавих шаардлага, тусгаарлалтыг бөх бат ба дулаан дамжуулах чанараар нь шалгах арга. Зуухны үндсэн шугам хоолойн схем, зуухыг засварт оруулахад бөглөө тавих газар, хэрэглэгдэх металлуудын шинж чанар (ширэм, ган, нержвек, бронз, баббит), ганг марклах арга, температураас хамаарч бэхэлгээний деталын ажиллах нөхцөл (гагнаасын, гагнаасын бус, тэнийлгэсэн гэх мэт) бэлтгэсэн хоолойг хэрэглэх хязгаар, нүүрстөрөгч багатай, бага никельдсэн хоолойг хадгалах, төрөлжүүлэх, зуухны засварын өмнө, дараа үеийн шингэн туршилтын дүрэм, зуухны тоног төхөөрөмжийн засварт хэрэглэгдэх тусгай багаж хэрэгслийн бүтэц, деталийн задаргаа, өргөх зөөх


машин-механизм, хэрэгсэл, хэв бэлтгэх ба тэмдэглэх, зуухны засварлагдаж буй элементийн (туслах тоноглол, арматур, агаар халаагч, экономайзер, буцлах систем) бүтэц, түүний засвар угсралтанд тавих шаардлага, диаметрээс хамааран хоолой металлын зөвшөөрөгдөх радиус, хоолой гагнах янз бүрийн төрөл, хэрэглэх электродны төрлүүд, гагнаасан холбоос хатаах, халаах төхөөрөмж, тавын гагнаас, голын төвлөрүүлэлт, төв ололт, хавчуулга (вкладыш) бэлтгэхэд хэрэглэх материал, гулсах ба өнхрөх холхивчийн ажиллах зарчим, араат дугуйн харьцааны төв ололт, араат дугуйг янзлах засварлах, засварт орсон тоноглолд орох тослох материалууд, өтгөрөлт, асах температур зэргийн үндсэн ойлголт шинж чанар, зохион байгуулалт, штангенциркуль, микрометр, (шүп) зай хэмжигч хэрэгслийн зориулалт, салхилуур, утаа сорогчийг угсрах арга, тэнхлэгийн ба хөндлөн цохилтын зөвшөөрөгдөх хэмжээ, ААД, ТАД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, компанийн хэмжээнд мөрдөгдөх дүрэм, журам, Эрчим хүчний салбарт мөрдөгдөх дүрэм, журам, бусад хууль тогтоомжууд.

ХИЙГДЭХ АЖЛЫН ЖИШЭЭ:

1. Өрлөг буулгах, өрлөг хийх хэмжээг тодорхойлно.
2. Зуурмаг, тоосго өрлөгт тохирох эсэхийг тодорхойлно.
3. Галын хотлоос утаа сорох хоолойн өрлөгийн шаваас (футеровка) хийнэ.
4. Өрлөгийн металл хийцтэй нийлэх, түүний зөв өрөгдөж байгааг шалгах, засна.
5. Заадсын зузаан, түүний босоо ба хэвтээ чигийн зөв эсэхийг шалгана.
6. Өрлөг шавардлагын хатаалтанд хяналт тавина.
7. Коллекторын тусгаарлагчийн өрлөг хийнэ.
8. Өндөр даралтанд ажиллах хаалт, арматурын их засвар хийнэ.
9. Краны операторчины мэргэжил эзэмшиж, үнэмлэхжсэн ажилтан нь өргөх, зөөх механизм дээр ажиллах
10. Зуухны нүүрс асаагуурыг солино.
11. Утаа сорогч, салхилуурын их болон урсгал засвар хийнэ.
12. Экономайзерын змеевикүүдийг угсрах, бэлдэх, солино.
13. Коллекторт нүх өрөмдөх, гагнууранд зориулж штуцер тавина.
14. Нүүрс тэжээгчийн их засвар хийнэ.
15. Халах гадаргуу бэлтгэх, ан цав, гулзайсныг засна.
16. Редукторын салах хавтгай ба холхивчийг цэвэрлэнэ.
17. Хоолой, змеевикийн шахалт хийнэ.
18. Шугам хоолойг нийлүүлэх, фаск гаргах, гагнуурт бэлтгэнэ.
19. Сорох, үлээх төхөөрөмжийг засварын дараа шалгана.
20. Фланцын холбоосонд нягтруулга солино.
21. Үеийн элс буух хоолойн засвар хийнэ.
22. Уутат шүүлтүүрийн механизмын засвар хийнэ.
23. Нарийн багж хэрэгсэлээр хэмжинэ. /микрометр, штангенцикуль/
24. Сантехникийн угсралт засвар үйлчилгээ хийнэ.
25. Хувийн хамгаалах хэрэгсэл /хөдөлмөр хамгааллын хувцас, гутал, каск/-ийг тогтмол, аюулгүй ажиллагааны дүрэмд заасны дагуу хэрэглэнэ. ААД, ТАД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, компанийн хөдөлмөрийн

дотоод журам, Эрчим хүчний салбарт мөрдөгддөг бусад хууль тогтоомжийн заалтуудыг мөрдөж ажиллана.

26.Техник ашиглалтын дүрэм, аюулгүй ажиллагааны дүрэм, ажлын байрны тодорхойлолт, тоног төхөөрөмжийн ашиглалтын заавар, галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, анхны тусламж үзүүлэх заавруудаар тогтсон хугацаанд ээлжит шалгалтыг өгсөн байна.

<p>БОЛОВСРУУЛСАН: Гүйцэтгэх Захирлын 2018 оны А/02 дугаар тушаалаар томилогдсон Мэргэжил, албан тушаалын тариф мэргэжлийн лавлах боловсруулах ажлын хэсэг</p> <p>Боловсруулж дууссан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр.</p>	<p>БАТЛАВ: Амгалан дулааны станц ХХК-ийн Гүйцэтгэх захирал</p> <p>Ш.Баянмөнх</p>  <p>Баталсан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр.</p>
<p>ХЯНАСАН: Зуухан цехийн Ашиглалтын инженер Э.Ариунболд Зуухан цехийн Засварын инженер Б.Боргил Захиргаа, удирдлагын хэлтсийн Хуулийн мэргэжилтэн Г.Саруул ХАБЭА-ийн инженер А.Энхжаргал</p>	

**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ХХК-НИЙ ЗУУХНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН
III ЗЭРГИЙН ЗАСВАРЧНЫ АЖЛЫН БАЙРНЫ ТАРИФ МЭРГЭЖЛИЙН
ЛАВЛАХ -7126**

АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

Бүрэн дунд ба түүнээс дээш боловсролтой, ЭХТСҮЦогцолборт Зуухны тоног төхөөрөмжийн засварчны мэргэжил эзэмшсэн, даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрмийн сургалтад хамрагдаж үнэмлэхжсэн байх, тоноглолын гэмтэлийг илрүүлэх чадвар эзэмшсэн, гал унтраагуул ашиглах чадвартай, хараа, сонсгол, амьсгалын замын болон зүрх судасны архаг үрэвсэл, харшилгүй, эрүүл чийрэг, сэтгэцийн ямар нэгэн өөрчлөлтгүй байх.

АЖЛЫН ТОДОРХОЙЛОЛТ:

Бүх төрлийн тоосго, галд тэсвэртэй материал, тусгаарлах материалаар өрлөг тусгаарлалтын ажил хийх, өрлөг тусгаарлалтанд үзлэг, температурын хэмжилт хийж гэмтлийг засварлах. Деталийг 3-4-р зэргийн нарийвчлалтайгаар слесарийн боловсруулалт хийж тэмдэглэсний дагуу хуурайдах, нүхлэх, деталиудыг төрөлжүүлэх, тэмдэглэх, шилжилт, секторон (нуман) нугалаас, конус ба бусад эд анги хийх, тосолгооны материалуудын төрөл анги чанарыг тодорхойлох эд ангийн төвөгтэй узелийг зургийн дагуу угсарч бэлтгэх, деталийг шахах голд халуун суулт хийх, голд өнхрөх холхивч суулгах, хийн даралтаар ажиллах багаж хэрэгсэлд туршилт, засвар хийх, вальцовка хийх, цуглуулагчийн таглааг солих, шугам хоолой, халах гадаргуугийн хоолойг гагнуурт бэлтгэх, мэргэжлийн өндөр зэрэгтэй засварчны хамтаар голд төвлөрүүлэлт хийх, бүх төрлийн төхөөрөмжийг задлах угсрах, төрөл бүрийн параметртэй зуухны халах гадаргууны хоолойг солих, засварын өмнө ба хойно зууханд шингэн (усан) туршилт хийх, зуухны тогоо коллектор, шугам хоолойг гагнасны дараа (гэмтлийг илрүүлэгч) шалгах, металлын гэмтлийг арилгах зэрэг ажлыг хийж гүйцэтгэнэ.

МЭДВЭЛ ЗОХИХ ЗҮЙЛ:


Засварлаж байгаа тоноглолын ажиллах зарчим, зориулалт, зохион байгуулалт, өрлөгийн зангилгааны хийц, өрлөг, тусгаарлалтанд орох материалын марк, технологи, шат тавцангийн зохион байгуулалт, шаардлага, зуухны халах гадаргуу, металл хийцийн температурын хөдлөлтийн өрлөгийн доторх зай, температурын заадсууд, тоосго өрөх арга, тогоо коллекторт вальцовка хийх технологи, агаар халаагчийн бүх систем, түүний нягтруулгыг засварлах, хоолойг халаан станок дээр матах арга, халах гадаргууны хоолойг засварлах ба гэмтсэн хэсгийг солих арга, үнсний шугамыг хамгаалах бугуйвч, оруулга, бүрхүүл зэргийг бэхлэх детальд тэмдэглэл хийх аргууд, параметрээс шалтгаалан бэхэлгээ, нягтруулга, арматур шугам хоолой, фланцад тавих шаардлага, засварт хэрэглэгдэх ган ба ширэмний үндсэн марк, халах гадаргууг цэвэрлэх, үлээлгийн ба цэвэрлэгээний аппаратыг ажиллуулах, үлээх сорох төхөөрөмж, галын хотол, халах гадаргуугийн засварт хэрэглэж буй тусгай багаж хэрэгслийн ажиллагаа, бүтэц, зориулалт, онцлог, ААД, ТАД, ГАУСД,

хяналт мэдээллийн систем, компанийн хэмжээнд мөрдөгдөх дүрэм, журам, Цахилгаан, хийн гагнуурын ашиглалтын үеийн болон Эрчим хүчний салбарт мөрдөгдөх дүрэм, журам, бусад хууль тогтоомжууд.

ХИЙГДЭХ АЖЛЫН ЖИШЭЭ:

1. Галд тэсвэртэй тоосгыг шахаж тааруулахаар цавчиж хасуурдана.
2. Шат тавцан барих зуурмагийн савыг байрлуулна.
3. Зуухны арын хана 2 ба 3-р утааны хоолойн утааны хамар, галын хотлын булан, хана зэргийг тусгаарлах өрлөг, утааны хийн хөндийн өрлөгийг хийнэ.
4. Асаагуур ба форсункийн цонх шагайвар нүх утааны хэмжүүр зэргийн өрлөгийг дахин өрнө.
5. Температурын заадсыг сэргээнэ.
6. Экономайзерын өрлөгийг нягтлана.
7. Усны болон хийн хаалт, гол, арматурыг өнгөлөх, зүлгэнэ.
8. Тогоонд дефектоскоп явуулахын тулд гагнуурын ба тавласан холбоосыг цэвэрлэнэ.
9. Тогооны гэмтсэн металлын ханан дахь ан цавыг тодорхойлно.
10. Голын хүзүүг өнгөлнө.
11. Араат дугуйны шүдийг зүлгүүрээр өнгөлнө.
12. Агаар халаагчийг засварлах, даралтаар шалгаж хоолойг солино.
13. Асаагуурын деталийг солих, засварлана.
14. Салхилуур ба утаа сорогчийг задлах, угсрах чиглүүлэгч аппарат ба хүрз солих ажлыг өндөр зэрэгтэй ажилтны удирдлага дор гүйцэтгэнэ.
15. Салхилуур ба утаа сорогчийг карман ба корпусын засвар хийнэ.
16. Хоолойн гуурс (змеевик)-ийг шараар шалгана.
17. Коллекторын үзүүр, салбарласан хэсгийн таглааг солих, харах түгжээг байрлуулна.
18. Үйлчилгээний шатыг галын хотолд угсрах, буулгана.
19. Эргэдэг, гинжин, туузан тэжээгчийг засварлана.
20. Сантехникийн угсралт засвар үйлчилгээ хийнэ.
21. Агаар халаагчийн халаагч хавтанг солино.
22. Редуктор задлах, угсарна.
23. Хоолойг нугалах станок дээр матна.
24. Хоолойн дамжуулагчийг гагнуурт бэлтгэж тусгай багажаар фаск хийнэ.
25. Уутат шүүлтүүрийн муудсан уутыг солино.
26. Хувийн хамгаалах хэрэгсэл /хөдөлмөр хамгааллын хувцас, гутал, каск/-ийг тогтмол, аюулгүй ажиллагааны дүрэмд заасны дагуу хэрэглэнэ. ААД, ТАД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, компанийн хөдөлмөрийн дотоод журам, Эрчим хүчний салбарт мөрдөгддөг бусад хууль тогтоомжийн заалтуудыг мөрдөж ажиллана.

27.Техник ашиглалтын дүрэм, аюулгүй ажиллагааны дүрэм, ажлын байрны тодорхойлолт, тоног төхөөрөмжийн ашиглалтын заавар, галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, анхны тусламж үзүүлэх заавруудаар тогтсон хугацаанд ээлжит шалгалтыг өгсөн байна.

<p>БОЛОВСРУУЛСАН: Гүйцэтгэх Захирлын 2018 оны А/02 дугаар тушаалаар томилогдсон Мэргэжил, албан тушаалын тариф мэргэжлийн лавлах боловсруулах ажлын хэсэг</p> <p>Боловсруулж дууссан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр.</p>	<p>БАТЛАВ: Амгалан дулааны станц ХХК-ийн Гүйцэтгэх захирал</p> <p> Ш.Баянмөнх</p> <p>Баталсан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр.</p> 
<p>ХЯНАСАН: Зуухан цехийн Ашиглалтын инженер Э.Ариунболд Зуухан цехийн Засварын инженер Б.Боргил Захиргаа, удирдлагын хэлтсийн Хуулийн мэргэжилтэн Г.Саруул ХАБЭА-ийн инженер А.Энхжаргал</p>    	

**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ХХК-ИЙН ЗУУХНЫ ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖИЙН II ЗЭРГИЙН ЗАСВАРЧНЫ АЖЛЫН БАЙРНЫ
ТАРИФ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ -7126**

АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

Бүрэн дунд ба түүнээс дээш боловсролтой, ЭХТСҮЦогцолборт Зуухны тоног төхөөрөмжийн засварчны мэргэжил эзэмшсэн, мөн даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрмийн сургалтад хамрагдаж үнэмлэхжсэн байх, тоноглолын гэмтэлийг илрүүлэх чадвар эзэмшсэн, гал унтраагуул ашиглах чадвартай, хараа, сонсгол, амьсгалын замын болон зүрх судасны архаг үрэвсэл, харшилгүй, эрүүл чийрэг, сэтгэцийн ямар нэгэн өөрчлөлтгүй байх.

АЖЛЫН ТОДОРХОЙЛОЛТ:

Тоноглолын хялбар зангилгаа хэсгийг угсрах, хагас муфт сугалах, даралтат болон шурган сугалагч /гидра болон винтен съёмник/ өнгөлгөөний болон өрмийн хийн ба цахилгаан багаж, хэрэгсэл эзэмших, таль демократ, гар тельфер лебёдка, погрузчикийн тусламжтайгаар өргөх зөөх хялбар ажил гүйцэтгэх. Ажлын байранд ба битүү саванд цахилгаан гагнуурчин болон огтлогчтой хамтран ажиллах. Техникийн зурагт зааснаар эд ангид тэмдэглэгээ хийх, нүхлэх, резьба татах, элэгдсэн резьбаг сэргээх, хаалт арматур, эд анги, турбаг нэр төрлөөр нь сонгох, засварт хэрэглэх материалыг чанар төрлөөр нь сонгон авах /жийрэг, чигжээс, өнгөлгөөний, угаах цэвэрлэх, шатах тослох материал, хоолой, пруток г.м/.


Өндөр мэргэжлийн засварчны удирдлаган дор дараах ажил үүргийг хийж гүйцэтгэнэ. Үүнд: Хариуцлагатай эд анги, хаалт арматур задлах, угсрах, шугам хоолой монтажлах, түүнийг усаар шахах, суурь машин дээр хоолой матах, зуухны болон тоос бэлтгэх тоноглол, үлээх, сорох төхөөрөмж, насос, хаалт арматурыг засварлах, эд ангийг өргөх, оосорлох. Бүх төрлийн тоосго, галд тэсвэртэй материал, тусгаарлах материалаар өрлөг тусгаарлалтын ажил ба гадаргуунд бүх төрлийн торкрет хийх, өрлөг тусгаарлалтанд үзлэг, температурын хэмжилт хийж гэмтлийн засварлана.

МЭДВЭЛ ЗОХИХ ЗҮЙЛ:

Дулааны станцын зарчмын схем. Слесарийн хянах хэмжих багаж /штангенциркуль, нутромер, угломер, глубиномер, микромер/-уудыг хэрэглэх, засварт хэрэглэгдэх металлуудын шинж чанар, марк, жийрэг, чигжээсний материал, тэдгээрийг шинж чанараас нь хамааруулан сонгож хэрэглэх, тосолгооны матеиалыг эд ангийн онцлог, зааврын дагуу сонгож хэрэглэх, шугам хоолойг гагнуурт бэлтгэх аргууд, өргөх, зөөх ажил хийх дүрэм, резьбаны төрөл бүрийн хэмжээнүүд, туслах ба өнхрөх холхивчны тухай үндсэн ойлголт, энгийн эд ангиудад тэмдэглэгээ хийх тухай, хоолойг матах, солих аргачлал, засварлаж байгаа тоноглолын ажиллах зарчим, зориулалт, зохион байгуулалт, өрлөгийн зангилгааны хийц, өрлөг, тусгаарлалтанд орох материалын марк, технологи, шат тавцангийн зохион байгуулалт, шаардлага, зуухны халах гадаргуу, металл хийцийн температурын хөдлөлтийн өрлөгийн доторх зай, температурын заадсууд, тоосго барих арга, ААД, ТАД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, компанийн хэмжээнд мөрдөгдөх дүрэм, журам, Цахилгаан, хийн гагнуурын ашиглалтын үеийн болон Эрчим хүчний салбарт мөрдөгдөх дүрэм, журам, бусад хууль тогтоомжууд.

ХИЙГДЭХ АЖЛЫН ЖИШЭЭ:

1. Өндөр мэргэжлийн засварчны удирдлаган дор дараах ажил үүргийг хийж гүйцэтгэнэ. Үүнд:
 - 1.1 Утаа, агаар, хийн хоолойд оруулга хийх, гэмтэл устгахад туслана.
 - 1.2 Эргэх механизмийн муфт сугална.
 - 1.3 Эргэх механизмын эд анги, масло насосын тос нэмнэ.
 - 1.4 Төрөл бүрийн шиберт үзлэг үйлчилгээ хийнэ.
 - 1.5 Фланецан холболтуудыг чангална.
 - 1.6 Огтлогч ба гагнуурчинтай хамтран ажиллана.
 - 1.7 Галд тэсвэртэй тоосгыг шахаж тааруулахаар цавчиж хасуурдана.
 - 1.8 Зуухны арын хана 2 ба 3-р утааны хоолойн утааны хамар, галын хотлын булан, хана зэргийг тусгаарлах өрлөг амбразур, хөндийд өрлөг хийх ажилд туслана.
 - 1.9 Шат тавцангийн бэлдэцийг зөөх, угсрах ажилд туслал
2. Хувийн хамгаалах хэрэгсэл /хөдөлмөр хамгааллын хувцас, гутал, каск/-ийг тогтмол, аюулгүй ажиллагааны дүрэмд заасны дагуу хэрэглэнэ. ААД, ТАД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, компанийн хөдөлмөрийн дотоод журам, Эрчим хүчний салбарт мөрдөгддөг бусад хууль тогтоомжийн заалтуудыг мөрдөж ажиллана.
3. Техник ашиглалтын дүрэм, аюулгүй ажиллагааны дүрэм, ажлын байрны тодорхойлолт, тоног төхөөрөмжийн ашиглалтын заавар, галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, анхны тусламж үзүүлэх заавруудаар тогтсон хугацаанд ээлжит шалгалтыг өгсөн байна.

<p>БОЛОВСРУУЛСАН: Гүйцэтгэх Захирлын 2018 оны А/02 дугаар тушаалаар томилогдсон Мэргэжил, албан тушаалын тариф мэргэжлийн лавлах боловсруулах ажлын хэсэг</p> <p>Боловсруулж дууссан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр.</p>	<p>БАТЛАВ: Амгалан дулааны станц ХХК-ийн Гүйцэтгэх захирал</p> <p> Ш.Баянмөнх</p> <p>Баталсан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр.</p>
<p>ХЯНАСАН: Зуухан цехийн Ашиглалтын инженер Э.Ариунболд Зуухан цехийн Засварын инженер Б.Боргил Захиргаа, удирдлагын хэлтсийн Хуулийн мэргэжилтэн Г.Саруул ХАБЭА-ийн инженер А.Энхжаргал</p>	

**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ХХК-НИЙ ЗУУХАН ЦЕХИЙН
ГАГНУУРЧНЫ VI ЗЭРГИЙН АЖЛЫН БАЙРНЫ
ТАРИФ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ-7212-25**

АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

Бүрэн дунд ба түүнээс дээш боловсролтой, ЭХТСҮЦогцолборт Гагнуурчны мэргэжлийн сургалтанд хамрагдаж VI зэргийн гагнуурчны үнэмлэх авсан, даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрмийн сургалтад хамрагдаж үнэмлэхжсэн байх, тоноглолын гэмтэлийг илрүүлэх чадвар эзэмшсэн, гал унтраагуул ашиглах чадвартай, зуухны тоног төхөөрөмжийн VI зэргийн гагнуурчны ажил үүрэг гүйцэтгэх хараа, сонсгол, амьсгалын замын болон зүрх судасны архаг үрэвсэл, харшилгүй, эрүүл чийрэг, сэтгэцийн ямар нэгэн өөрчлөлтгүй байх.

АЖЛЫН ТОДОРХОЙЛОЛТ:

Янз бүрийн ган ба өнгөт металл, хайлшаар хийгдсэн төхөөрөмж, зангилгаа, хийц, шугам хоолой динамик ба доргионтой ачаалалд ажилладаг болон барилгын технологийн нарийн хэлбэр дүрстэй хийцийг цахилгаан нуман болон хийн цахилгаан гагнуураар гагнах. Гагнагдах хязгаартай металл, хайлш болон титан, түүний хайлшаар хийгдсэн сорилтын хийц блок ажиллагаатай хийцийг янз бүрийн байрлалд гагнах, динамик чичиргээтэй ачаалалт даралтад ажиллахад зориулагдсан эд анги эдлэлүүдийг плазмаар буюу хийгээр гагнах. Динамик чичиргээтэй ачаалалтад ашигладаг болон технологийн онц хариуцлагатай хийц, мөн нарийн хэлбэр дүрс бүхий хийцүүдийг нум, цахилгаан, хийгээр гагнах, чанаржуулсан, тусгай ган, титан болон бусад хайлшаар хийсэн нарийн хийцтэй, хариуцлагатай эд ангиудыг тусгай хийцээр автомат, олон нум, электродтой автомат болон бусад хэрэгслүүдийг хэрэглэж автоматаар гагнах. Динамик, чичиргээт ачаалалд ажилладаг онц хариуцлагатай аппарат, зангилаа, дамжуулах хаалт, барилгын ба технологийн хийцүүдийг босоо буюу таазны байрлалд гагнах.

Бүх төрлийн тоосго, галд тэсвэртэй материал, тусгаарлах материалаар өрлөг тусгаарлалтын ажил хийх, өрлөг тусгаарлалтанд үзлэг, температурын хэмжилт хийж гэмтлийг засварлах, өрлөг шавардлага, тусгаарлалтын гологдлыг илрүүлж устгах, өндөр параметртэй дулааныг дамжуулах шугам хоолойн тусгаарлалтын ба өрлөг тусгаарлалтын хариуцлагатай ажлыг хийж гүйцэтгэх болон засварын бригадыг удирдах, бүх төрлийн өрлөг тусгаарлалтыг зургийн дагуу, бүх параметрийн зуухны өрлөгийн их засвар хийх, засварын ажлын эзлэхүүн тодорхойлох, нэг үет тусгаарлалтын температурыг тодорхойлох, туршилт хийх, шаардлагатай материалыг сонгох, зуухны агрегатын бэлэн болсон өрлөгийг шалган хүлээн авах ба галд тэсвэртэй нарийн зуурмаг бэлтгэх, зуухны агергатын эд ангийг угсрах, засварлах, задаргаа хийх, тоноглолын тусгай эд ангийн түргэн элэгдлийн шалтгааныг тодорхойлох, гагнуурын формуляр хөтлөх ба хэмжилт үйлдэх, эд ангийн зангилгааг зурагтай тохируулан хянах, бүх төрлийн шугам хоолойн нягтруулгыг зургийн дагуу хийж гүйцэтгэх.

Бүх төрлийн хамгаалах клапан тохируулах, ямар ч системийн арматурын засвар ба деталийг бэлдэх ба коллекторын суурийг шинэчилж

байрлуулах, хаалтны нягтруулах гадаргуугийн сэргээлт, редукторыг солих, бүх төрлийн насос, утаа сорогч, салхилуурын голд төвлөрүүлэлт хийх, өргөх зөөх хэрэгсэл, хийн, цахилгаан багаж хэрэгсэлийн тусламжаар ажил гүйцэтгэх, бригадын гүйцэтгэсэн ажлыг шалгах, хүлээн авах, складаас авч буй запас хэрэгсэл нь техникийн нөхцөл, шаардлагын хэмжээнд тохирох эсэхийг шалгах, засвараас гарсан тоноглол эд ангийг бэлтгэх болон зуухны агрегатын механизмыг шалгаж туршин ачаалал авахуулж ашиглалтанд хүлээлгэн өгөх, засаж буй машин, агрегат тоног төхөөрөмжийн хийцийн онцлог, тэдгээрийн /физик, механикийн үндсэн хуулиуд/ кинематикийн болон гидросхем, тоног төхөөрөмжийг засах, угсрах, ажиллагааны нарийвчлалыг шалгах болон тэдгээрийг засварын дараа механизмын ачааллын дээд хэмжээ, хугарах, зэвэрч элэгдэх ба осол гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах ажлыг гүйцэтгэх.

МЭДВЭЛ ЗОХИХ ЗҮЙЛ:

Янз бүрийн титаны хайлш тэдгээрийн гагнагдах ба механик шинж чанар, зэврэлт түүнээс хамгаалах, гагнагдсан эзэлхүүнийг турших тусгай арга.

Гагнуурын аппаратны төрөл, зохион байгуулалт, оёдол ба огтлолын дараахь гадаргууд тавих шаардлага электродын хучлагын шинж чанар, ач холбогдол. Гагнуурын холболтыг дулаанаар боловсруулах үндсэн хэлбэр. Гагнуурын аппаратны төрөл, оёдол, металл судлалын тухай ойлголт Титаны хайлшийн төрөл, гагнуурын аппарат, автомат, хагас автомат, тэжээл үүсгүүрийн цахилгаан схем, хийц, чанаржуулсан ган, гагнаж байгаа металл болон зорлого хийгдэх, шавах металлын технологийн шинж чанар, гагнуурын оёос тавих технологийн дэс дараалал, гагнах горимын сонголт гагнуурын оёосыг шалгах, турших аргууд гагнуурын оёосны шинж чанарт илчийн боловсруулалтын үзүүлэх нөлөө, илчээр боловсруулах үндсэн төрлүүд, физик-механикийн үндсэн хуулиуд,

